

РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXII • 2019 • № 2

Выходит 2 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: Федеральное государственное учреждение науки
«Институт восточных рукописей РАН»

**Посвящается 70-летию юбилею российского
монголоведа Ирины Владимировны Кульганек**

191186. Санкт-Петербург.
Дворцовая наб., д. 18
Тел. (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru

Редакционная коллегия:

- И. В. Кульганек, *главный редактор,
доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук
(Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чешская Республика)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Л. Г. Скородумова, *доктор филологических наук (Россия)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук,
профессор (Россия)*
С. Чулуун, *доктор исторических наук, профессор
(Монголия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет изготовлен издательством «Петербургское Востоковедение»
Литературный редактор и корректор — Т. Г. Бугакова
Технический редактор — Г. В. Тихомирова

✉ 198152, Россия, Санкт-Петербург, а/я № 2
e-mail: pvcentre@mail.ru; *web-site:* <http://www.pvost.org>

Подписано в печать 13.11.2019
Формат 60×90 1/8. Объем 13 печ. л. Заказ №

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,
Санкт-Петербург. 4-я линия В. О., д. 5. *e-mail:* editor@isvov.ru

ISSN 2311-5939
DOI 10.25882/6rgv-sz04

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2019

Ч. Батдорж

Судар бичгийн хүрээлэнд ажилласан оросын гурван оюутан (1923–1926)

(О работе трех русских студентов в Ученом комитете Монголии (1923–1926))

DOI 10.25882/85t6-3s28

© Ч. Батдорж, 2019

Летом 1923 г. в Монголию прибыли В. А. Казакевич, Н. Н. Бабынин и А. В. Петров — студенты Петроградского института живых восточных языков (ПИЖВЯ/ЛИЖВЯ) для прохождения практики в Монгольском Ученом комитете при поддержке Академии наук и своих руководителей — В. Л. Котвича и Б. Я. Владимирцова. Из них самым активным и плодотворным оказался В. А. Казакевич, который в течение всего срока своего пребывания в стране участвовал в 5 экспедициях и принимал деятельное участие в комиссии по составлению новых терминов. Н. Н. Бабынин также принимал участие в работе комиссии и ездил в экспедицию в Мерген-гуновский хошун Сайн-нойон-хановского аймака. По всей видимости, А. В. Петров вернулся в Россию после шестимесячного изучения монгольского языка в Сэцэн-хановском курене Сэцэн-хановского аймака. Осенью 1925 г. вернулись В. А. Казакевич и Н. Н. Бабынин. Монгольский Ученый комитет наградил В. А. Казакевича почетной грамотой за успешное выполнение многочисленных поручений и задач, поставленных перед ним Комитетом. Успешная практика этих студентов в Монголии открыла новую страницу в монголоведении.

Ключевые слова: Петроградский институт живых восточных языков, Монгольский Ученый комитет, экспедиция, монгольский язык, монголоведение, Сэцэн-хановский аймак, Сайн-нойон-хановский аймак, Монголия, В. А. Казакевич, Н. Н. Бабынин, А. В. Петров, Ж. Цэвээн (Ц. Ж. Жамцарано).

1921 онд Монгол улсад Ардын засаг тогтож, төр улсаа орчин цагийн улс болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэ зорилтын хүрээнд Монгол улсын шинжлэх ухааны анхны байгууллага Судар бичгийн хүрээлэнг Ардын Засгийн Газрын харьяанд 1921 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан [Сэрээтэр, 2002. С. 12–13] юм. Судар бичгийн хүрээлэнгийн анхны даргаар С. Жамьянг, нарийн бичгийн даргаар Ж. Цэвээнийг, хавсарсан нарийн бичгийн даргаар Ц. Бат-Очир нарыг тус тус томилсон байдаг.

Судар бичгийн хүрээлэнгийн дэвшүүлсэн зорилгын нэг нь европын боловсролыг эзэмшсэн залуу боловсон хүчнийг бэлтгэх явдал байв. Гиймээс анх байгуулсан цагаас эхлэн Ж. Цэвээн өөрийн багш монгол судлаач Б. Я. Владимирцов, С. Ф. Ольденбург нарын нэртэй эрдэмтэн судлаачидтай холбоо тогтоохын зэрэгцээ зарим албан байгууллагуудтай мөн харилцаж эхэлжээ. Энэ нь Орос, Монгол хоёр улс нь улс төрийн хувьд харилцан найртай болж, монголчууд Зөвлөлтийн чиг шугамыг дагах болсонтой холбоотой байв.

1923 онд Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн тэргүүлэгч гишүүдийн шийдвэрээр Ц. Дамбадорж, Б. Дорж, А. Гарсай нарыг гурван оюутныг Петроградын Дорно дахины хэл бичгийн сургууль¹-д суралцуулахаар илгээжээ. Үүнтэй зэрэгцээд Петроградын Дорно дахины хэл бичгийн сургуулийн, монгол хэл бичигт сургах, эрдэм шинжилгээний дадлага хийлгэх зорилгоор Монголын Судар бичгийн хүрээлэн рүү гурван орос оюутныг илгээсэн юм. В. А. Казакевич, Н. Н. Бабынин, А. В. Петров нарын эдгээр оюутнууд нь монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов шавь Оросын Шинжлэх Ухааны Академийн нарийн бичгийн дарга С. Ф. Ольденбургийн тусламжтайгаар Монголд иржээ. [Юсупова, 2018. С. 61].

Дорно дахины хэл бичгийн сургуулийн анхны захирал, монголч эрдэмтэн В. Л. Котвич [Улымжиев, 1998. С. 128] нь судалгааны ажил хийхийн зэрэгцээ, монголыг судлах судлаачдыг бэлтгэх талаар онцгой анхаарч байсан юм. Тэрбээр эдгээр гурван оюутныг Монгол руу илгээсэн тухай А.Б. Бурдуковт бичсэн захидалдаа, залуу үеийг дэмжих нь шаардлагатай

¹ ПИЖВЯ, 1924 оноос ЛИЖВЯ.

байгаа бөгөөд үүнийг зохион байгуулахын тулд, би гурван залууг Өргөө рүү илгээж байна. Дөнгөж эхэлж буй монгол судлаачид ардуудтай амьд холбоо үүсгэн, судална хэмээн найдаж буй [Котвич, 2011. С. 29] хэмээн өгүүлжээ.

Тэдгээр Орос оюутнууд нь 1923 оны 7 дугаар сарын сүүлээр Монголд ирсэн бололтой байна. Судар бичгийн хүрээлэнгийн тэргүүлэгчдийн 1923 оны 7 дугаар сарын 31 өдрийн хурлаар, Зөвлөлт Орос Улсын нийслэл Петроград² хотоос орос гурван оюутан манай монгол газар сууж, монгол хэл бичиг сурах зэрэг хэргээр хүрэлцэн ирсэн тухай асуудлыг хэлэлцжээ. Тус хурлын протоколд: «орос оюутан гурван хүн монголын газараа нэгэн жил сууж, монгол бичиг хэл сурах зэрэг хэргээр манай хүрээлэнд илгээсэн Казакевич хэмээгч франц, герман, орос гурван улсын бичиг хэл, Бабынин хэмээгч нь англи, герман, франц, орос дөрвөн улсын бичиг хэл, Петров хэмээх нь дан орос бичиг хэл мэдэх ийм гурван оюутан бөгөөд үүнд хянаваас, Монголоос Оросын нийслэлд эрдэм сурахаар очсон хүнийг туслан хамгаалах ба бас ч найртай ёсыг илэрхийлбээс зохих учирт, харьяат хүрээлэнгийн эрдэм соёл мохошгүй зорилгоос хүн бүр сар тутам гучин таван лан олгож тусламж үзүүлэх ба ялдараа харьяат хүрээлэнд тэдний мэдэх хэлний бичиг судар орчуулгах зэрэг явдлыг Засгийн Газараа мэдүүлж батлуулахаар хэлэлцэн тогтов»³ хэмээн бичсэн байна.

Эдгээр оюутнууд нь Монголд ирсэн даруйдаа Судар бичгийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд оролцож, хэрийн судалгааны ажилд явжээ. Тэдний анхны томилот нь Өргөө хотоос 30 гаруй километр орчмын зайтай Налайх дахь Түрэгийн үеийн бичигт, хөшөө чулуу болон мөн тэндэх чулуун нүүрсний уурхайг шинжлэн үзэхээр явцгаажээ. Мөн оны 8 дугаар сарын эхээр судалгааны багийг Судар бичгийн хүрээлэнгийн инженер В. И. Лисовский ахлан, түүнийг дагалдан орчуулагч Б. Дорж, бичээч Н. Дэндэв, Жанцансамбуу, Содов нарын оюутан В. А. Казакевич, А. В. Петров, Шастин, жолооч Рожин нарын 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр явжээ⁴. Судалгааны багийнхан Налайх дахь эртний Түрэг улсын мэргэн сайд Тоньюкукийн гэрэлт хөшөөг очиж үзэхийн зэрэгцээ Налайхын чулуун нүүрсний нөөцийг анх удаа магадлан үзсэн байна. Налайх руу явсан судалгааны багт Н. Н. Бабыниныг явуулаагүй байна.

Баримтаас үзэхэд В. А. Казакевич, А. В. Петров нар нь Налайхад төдий л удаагүй бололтой. Тэднийг буцаж ирсний дараа, тэдгээр гурван оюутныг тус тусад нь өөр өөр судалгаа хийлгэх болон хэл сургах зэргээр салган явуулжээ. Энэ гурван оюутны дотор монгол хэлийг арай илүү сурсан нь В. А. Казакевич байсан бололтой. Тиймээс түүнийг хуучны монгол

бичгийн дурсгал бүхий хөшөө чулууг судлуулах ажлаар Сэцэн хан аймгийн Ахай бэйсийн хошуу [Одоогийн Дорноговь аймгийн Их хэт сум]-ны нутаг дахь Бүсийн чулуу хэмээх газарт буй Хэсэг байшин хэмээн хуучны балгасын хөшөөний бичээсийг хуулбарлуулахаар Д. Нацагдоржийн хамт явуулсан байна. Энэ тухай Судар бичгийн хүрээлэнгээс Дотоод явдлын яаманд илгээсэн бичигт: «Казакевич нарын биед унах морь хоёр, ачих морь нэг, морьтой улаач хүн нэгийг хэрэгсэх арван таван хоногийн зарлал бичиг шийтгэн олговоос болох ажааму. Үүний тул хуудас өргөн илгээв. Олноо Өргөгдсөний 13 дугаар он 7 дугаар сарын шинийн 1, европын 8 дугаар сарын 13 өдөр»⁵ хэмээн бичжээ.

Ийнхүү хожмын их зохиолч Д. Нацагдорж, В. А. Казакевич нар Хэсэг байшингийн хөшөөний бичээсийг судлахаар 15 хоногийн хугацаатайгаар явжээ. Тэр хоёрыг Хэсэг байшингийн сууринд очиход монгол бичээс бүхий хөшөө нь хэдэн хэсэг болон хуваагдсан байсан ч бичээсийн хэвийг хоёр хувь авч чадсан аж. Судар бичгийн хүрээлэнгийн дарга С. Жамьян, Ж. Цэвээн нар нь Хэсэг байшинг тус газараа бүхий хөшөөний бичээсийн хэв маяг, агуулгаас хараад Халхын Абтай сайн хааны үеийнх болохын зөв тодорхойлжээ. Үлдсэн нэг хувийг Судар бичгийн хүрээлэнгээс эрдэмтэн В. Л. Котвичид илгээсэн байна⁶. Судар бичгийн хүрээлэнгээс В. Л. Котвичид илгээсэн захидлын агуулгаас харахад, Хэсэг байшингийн балгасанд монгол бичээс бүхий гэрэлт хөшөө байгааг очиж үзэхийг В. Л. Котвич санал болгосон нь харагддаг. В. Л. Котвичид илгээсэн хөшөөний бичгийн хуулга Оросын Шинжлэх Ухааны Академийн Азийн музейд хадгалагдаж байгааг Б. Я. Владимирцов өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

Оюутан Н. Н. Бабыниныг Сайн ноён хан аймгийн Мэргэн гүний хошууны зэрэг газруудад хуучин бичигтэй хөшөө чулуу ба түүх монгол хэлний аяс зэргийг шинжлэн үзэхээр явуулжээ⁷. Н. Н. Бабыниныг судалгаа хийлгэхээр ганцааранг нь явуулсан нь түүний монгол хэлний мэдлэг муугүй байсныг илтгэж байна. Харин оюутан А. В. Петровыг монгол хэл сургахаар Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хүрээ рүү явуулжээ. Түүнд Судар бичгийн хүрээлэнгээс олгосон тэмдэг бичигт: «манай хүрээлэнгийн албанд хэрэглэх Петровын биеийг Сэцэн ханы хошууны газраа сууж, монгол хэл бичиг сургахаар явуулсны тулд, аливаа замд тохиолдсон учрыг ухааж саадгүй шудрагаар өнгөрүүлтүгэй хэмээхээс гадна, оюутан орос Петровын хүрсэн газар орны лам ноёд, түшмэд, цэрэг, ард нар нийтээр батлан хамгаалж, уг хэрэгт тусламж үзүүлэх ажааму хэмээн үүний тул тамга дарсан үнэмлэх бичиг шийтгэн олгов»⁸ хэмээсэн байна.

Судар бичгийн хүрээлэнд ирсэн гурван оюутныг тус бүрд нь тохирсон ажлыг хийлгэхээр гурван тийш

² 1923 онд ЗОУ-ын нийслэл нь Москва байв. Баримтад нийслэл Петроград хэмээн ташаарчээ.

³ Монгол улсын Үндэсний Төв архив. Хөмрөг. 23. Данс. 1. Хадгаламжийн нэгж. 17. Хуудас 113. Үүнээс хойш МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 113 гэж товчилно.

⁴ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 21. х. 32.

⁵ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 118а.

⁶ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 130.

⁷ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 118.

⁸ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 121.

явуулсны дараа Ж. Цэвээн Петроградын Дорно дахины хэл бичгийн сургуулийн захиралд тусгайлан захидал илгээв⁹. Захидалд: «Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгээс Петроград хотод бүхий Дорнодахины олон хэлний сургуулийг захирах их эрдэмтэн түшмэл Ректор танаа амгаланг эрмүй. Мөнө-өхөн эрхэм сургуулийн газраас ирсэн Казакевич нарын гурван оюутан хүнийг манай Судар бичгийн хүрээлэнгийн газраа найртай ёсоор хүлээн авч, сар тутам хүн бүр тавин янчааны хэрэглэл олгож, хагас жилээр Халхын харьяат нутгийн дотор монгол хэл бичиг сурахуйц газрыг сонгож тус тус суусан бөгөөд хойч өдөр хоёр этгээдээс энэ мэт эрдэм сурагчдыг харилцан нэгэн адил тусламж үзүүлэн хамгаалваас маш зүйтэй болох замыг нээж, танай сургуулийн газарт манай Ардын Засгийн газраа хэвлэн гаргасан улсын бага сага дүрэм хүрээлэнгээс хэвлэсэн ном бичиг зүйлээс тус тус нэжгээд хувийг тус сургуулийн Санд талархан хүргүүлэв. Хүрмэгц тооны ёсоор хүлээн авч сонирхох ажааму хэмээн үүний тул Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайд Жамьян, эрхэлсэн түшмэл Цэвээн нар хичээнгүйлэн ёслол. Олноо Өргөгдсөний 13 дугаар он 7 дугаар сарын 21, аргын улирлын 9 сарын 1 өдөр»¹⁰ хэмээн бичжээ.

С. Жамьян, Ж. Цэвээн нарын захидлаас харвал гурван орос оюутныг тус бүрт нь тохирох судалгааны ажил болон дадлага хийлгэх боломжийг бүрдүүлэхийг хичээхийн дээр Засгийн газраас зөвшөөрсний дагуу сар тутам 50 янчааныг амьдрах зардал болгон цалин хэлбэрээр олгох болжээ. Энэ нь 1924 оны эхээр А. В. Петровын Сэцэн ханы хүрээний газраас Судар бичгийн хүрээлэнгийн тэргүүлэгчдэд бичсэн захидлын хуулбараас тодхон харагдаж байна. Үүнээс гадна А. В. Петровын захианд өвлийн гурван сарын цалин 150 янчааныг Сэцэн ханы хошууны лам Лувсанцэдэнгээр дамжуулан авсан¹¹ тухай бас дурдсан байдаг.

Сайн ноён хан аймгийн Мэргэн гүний хошуу руу явсан Н. Н. Бабынины үйл ажиллагааны тухай магадлах баримт төдий л илэрсэнгүй.

Эдгээр гурван оюутнаас хамгийн идэвхтэй ажилласан нь В. А. Казакевич юм. Хэсэг байшинд ажиллаад ирснийхээ дараа тэрээр Өргөөгөөс өмнө чигт судалгаагаар дахин явжээ. Судар бичгийн хүрээлэнгээс олгосон тэмдэг бичигт: «Орос оюутан Казакевичийн биеийг газарчлан дагалдан хүн нэгийн хамтаар бие хамгаалах буу нэгийг авахуулан, Түшээт хан аймгийн Мэргэн ван, Түшээт ван нарын зэрэг хошуунаа илгээж, тэдний хошуудын нутгийн зах зурхайг байцаан үзүүлж, зураг цэсийг нарийвчлан засаж үйлдүүлэх ба хуучин түүх судар бичгийн зүйлийг олох зэрэг хэргээр... тул үнэмлэх бичиг шийтгэн олгов. Олноо Өргөгдсөний 13 дугаар он, 7 дугаар сарын 29-ний өдөр, аргын улирлын 9 дүгээр

сарын 9 өдөр¹² хэмээн бичжээ. Энэ удаагийн судалгаагаар Монгол улсын өмнөд хил хүртэл явж, сантиметрт 5 мод багтаасан масштабаар өмнөх хил ба сав нутгийн зургийг авч ерөнхий географи (газар орны)-ийн байдлыг нягтлан бичсэнээс гадна, тус нутгийн ардын аж байдлын тухай тэмдэглэв. Жич хуучны дурсгалын бүхий юмсыг шинжиж, чулуун нүүрс, цагаан тугалга бүхий газруудыг тодорхойлов»¹³ хэмээн Судар бичгийн хүрээлэнд үлдээсэн товч тайланд бичжээ.

1924 он гарснаар Судар бичгийн хүрээлэн нь бүтэц, зохион байгуулалтаа тодорхой болгосны дээр, тус хүрээлэнгийн цаашдын зорилтыг тодорхойлсон «Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо» хэмээх баримт бичгийг зохион гаргаж, Засгийн газраар батлуулсан юм. Энэ зорилтын хүрээнд Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд Ж. Цэвээнээр толгойлуулсан «Нэр томьёоны комисс»-ыг байгуулсан юм. Тус комисс нь дотроо арван салбар комиссыг байгуулж, аливаа нэр томьёог тогтоохдоо баримтлах дүрэм, зааврыг тогтоож¹⁴ өгчээ. Энэхүү нэр томьёо тогтоох ажилд Ж. Цэвээн орос оюутнуудыг татан оролцуулсан байна. Жишээлбэл, арван салбар комиссын Түмэн бодис, ургамал, чулуу ба амьтны комисст Н. Н. Бабынин орж ажилласан бол В. А. Казакевичийг Дэлхийн байдал ба олон улсын түүхийн комисс, Гадаадаас авсан нэрсийг хэрхэн бичих комисст оруулан ажиллуулсан байна. Энэ нь тухайн үед Судар бичгийн хүрээлэнд гадаадын олон хэл, бичгийг мэдэх мэргэжилтэн дутагдалтай байсныг харгалзан үзээд франц, герман, орос гурван улсын бичиг хэл мэдэх В. А. Казакевич, англи, герман, франц орос дөрвөн улсын бичиг хэл мэдэх Н. Н. Бабынин нарыг нэр томьёо тогтоох ажилдаа татан оролцуулсан хэрэг билээ.

Н. Н. Бабынин, А. В. Петров нар нь 1924 онд ямар ажил хийж байсан талаар өөр тодруулсан баримт Монгол Улсын Үндэсний Төв архивт тааралдсангүй. Б. Я. Владимирцовоос В. Л. Котвичид 1924 оны 2 дугаар сарын 29-ний өдөр бичсэн захидлаас үзэхүл, А. В. Петров 6 сарын хугацаанд Сэцэн ханы хүрээнд сууж монгол хэл, бичигт суралцсан мэдэгдэж байгаа бол Н.Н. Бабынин, В.А. Казакевич нар Өргөөд хүрэлцэн ирсэн байна [Владимирцов, 2016. С. 130].

Тэд 1924 оны 6 дугаар сарын 5–17-ны хооронд, Судар бичгийн хүрээлэнгийн инженер, газрын зураг үйлдэгч В. И. Лисовскийн хамт Туул, Хэрлэн голын эхээр явж, топограф болон геологийн зураг үйлдэн, музейн үзмэр цуглуулжээ.

В. А. Казакевичийн хувьд түүнийг 1924 оны 7 дугаар сараас Монголын өмнө талын хилээр явсан судалгааны ажлаа үргэлжлүүлэн явуулахыг Судар бичгийн хүрээлэнгээс шийдвэрлэсэн байна. Хилийн бүс нутгаар явж буй учир Монгол Улсын Дотоод явдлын яамнаас тусгайлсан зөвшөөрлийг авчээ. Түүний гол зорилгыг Монгол улсын өмнөд хилийн

⁹ Энэ үед тус сургуулийн захирлын албыг хашиж байсан В. Л. Котвич нэгэнт уг албыг өгч, түүний оронд П. И. Воробьев томилогдсон юм.

¹⁰ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 128а.

¹¹ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 57а.

¹² МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 17. х. 133.

¹³ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 161. х. 50.

¹⁴ МУУТА. Х. 23. Д. 1. Хн. 42. х. 1–7.

зургийг үйлдэх, музейн үзмэр цуглуулах хэмээн түүнд олгосон тэмдэг бичигт бичжээ. 1923 оны өвөл, Монголын өмнөд хил хүрээд буцсан бол энэ удаад өмнөд хилийн дагуу явах учир тухайн үеийн Монгол улсын Цэцэрлэг мандал, Хан тайшир уулын хоёр аймгийн нутаг ба Ховдын хязгаар газрын хилийн дагуу явах учир цаг хугацаа нэлээд зарцуулахаар байв. Түүнтэй хамт орос Багумов, лам Жамц хэмээх хоёр хүнийг дагалдуулан явуулжээ. Хамгийн сонирхолтой нь Судар бичгийн хүрээлэнгээс хилийн дагуу ажиллах зөвшөөрлийг хүссэн Дотоод яаманд илгээсэн бичигт: «Казакевич хэмээх Дэлгэр»¹⁵ хэмээн бичсэн нь түүнийг монголчууд А. Д. Симуковын «Шар Дамдинсүрэн» гэж хочлон дууддаг шиг «Дэлгэр» хэмээн монгол нэр өгч хочлон дуудаж байсныг харуулж байна. Энэ нь түүнийг монголчуудтай чөлөөтэй харилцан, тэдний дунд нэр хүнд өндөр байсныг илтгэж буй хэрэг юм.

Монголын өмнөд хилийн дагуу явсан В. А. Казакевич, «зорчлон газрын ерөнхий географийн байдал, ургамал, адгуусны зүйл, хуучны дурсгал бүхий юмс оршин суух хүмүүсийн байдал зэргийг тэмдэглэсэн дэлгэрэнгүй илтгэл бичиж, (алтан харуул)-ын тухай шинжин үзэж, тариалан ба баруун өмнө хязгаарын замуудын чиг ба дээрэм хулгайн тухай зүйлүүдийг нягтлан тэмдэглэж, Тамчийн давааны орчим бүхий чулуун нүүрсийг зааж, геологи (газрын хөрс тогтсон ёсыг шинжлэх ухаан) бяцхан коллекцуудыг цуглуулав»¹⁶ хэмээн бичжээ.

В. А. Казакевичийн 1924 онд явсан хоёр удаагийн тайлан нь эдүгээ Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнд хадгалагдаж буй бол бусад тайлан илтгэлүүд нь ОХУ-ын Санкт-Петербург хотын Улсын Түүхийн төв архив болон Дорно дахины гар бичгийн хүрээлэнд тус тус хадгалагдаж байна [Носов, 2019. С. 54].

Монголд байх хугацаандаа хамгийн идэвхтэй байсан В. А. Казакевич нь монгол хэл, соёлын тухай судлахын зэрэгцээ амьтан, ургамлыг сонирхон цуглуулга хийж, Судар бичгийн хүрээлэнгийн музейд цуглуулж байсны дээр заримыг нь Ж. Цэвээн Оросын Шинжлэх Ухааны Академийн Зоологийн музейд дамжуулан өгсөн байна. [Козлов, 2003. С. 414, 416].

Судар бичгийн хүрээлэнгээс дараагийн удаа 1925 онд, В. А. Казакевичийг Шастин хэмээх орос оюут-

ны хамт Дотоод явдлын яамны түшмэлийн хамтаар Монгол улсад дагаар орсон буриад-монголчуудыг хошуу сум зохиож, аймаг хошуунд хавсруулан тусгайлан газар нутаг хэмжээлэн заан олгож буй зэрэг явдлыг үзжээ¹⁷. Үүнээс гадна «Халх голын орчмын зургийг 5 см-г багтаасан маштабаар хэмжин ерөнхий географийн байдал ургамал, адгуусны зүйл нутаглан суугаа ардын байдал хийгээд хилийн хоёр этгээдийн ардуудын хоорондын харилцаа мэтсийг тэмдэглэхийн зэрэгцээ бяцхан коллекцуудыг цуглуулсан»¹⁸ хэмээн товч тайланд дурджээ.

Сэцэн ханы хүрээ рүү явж монгол хэл бичиг суралцахаар явсан А. В. Петров нь 1924 оноос нутаг буцсан бололтой. 1925 онд монголч эрдэмтэн, гурван оюутны багш Б. Я. Владимирцов, буриадын эрдэмтэн Б. Б. Барадины хамт Монголд ирэхэд, А. В. Петров нэгэнт буцсан байв. В. А. Казакевич, Н. Н. Бабынин нар багштайгаа хамт монгол удган дээр очиж, ямар зан үйл хэрхэн хийж буй талаар судалгаа хийхэд нь явцгаасан байдаг¹⁹ [Номинханов, 2016. Т. 176]. Б. Я. Владимирцовын нутаг буцсаны дараа, 1925 оны 10 дугаар сарын сүүлээр В. А. Казакевич, Н. Н. Бабынин нар Монголд хоёр жилийн хугацааг өнгөрүүлээд, Ленинград хот руугаа буцсан байна [Владимирцов, 2016. С. 150].

Эдгээр оюутнуудаас В. А. Казакевич нь хожим нэртэй сайн судлаач болж, монголд дахин хэдэн удаа ирж, судалгаа хийсэн юм. Түүний Дарьгангад явсан хээрийн судалгаа нь маш алдартай бөгөөд, Дарьганга судлал төдийгүй Монголын эзэнт гүрний үеийн хүн чулууны тухай анхны томоохон судалгаа болжээ.

Оросоос Монголд ирсэн гурван оюутны нэг нь 1 жил гаруй, үлдсэн хоёр нь 2 жил гаруй Монголд байж, өөр өөрсдийн чиглэлээр монгол хэл, бичиг сурахын зэрэгцээ цаашдын судалгааны сонирхол чиглэлийг олж авчээ. Тэр хоёр бол Судар бичгийн хүрээлэнгийн томиллолтоор олон удаагийн хээрийн судалгаанд явж, шинэ тутам байгуулагдсан Монгол улсын шинжлэх ухааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцогсод байсан юм. Хэдий богино хугацааг Монголд өнгөрүүлсэн боловч эдгээр оюутнууд Монгол, Оросын шинжлэх ухааны судалгаанд өөрсдийн мөрийг үлдээсэн бөгөөд түүнийг нь судлах шинжлэх ажил дөнгөж эхлэлийн байдалтай байна.

Ном зүй

Владимирцов, 2016: *Владимирцов Б. Я.* Письма. Неизданное / сост. Г. И. Слесарчук, А. Д. Цендина. М.: Наука, Вост. лит., 2016. 389 с. (*Vladimirtsov B. Ya. Pis'ma. Neizdannoye / sost. G. I. Slesarchuk, A. D. Tsendina. M.: Nauka; Vost. lit., 2016. 389 s.*)

Козлов, 2003: *Петр Кузьмич Козлов.* Дневники Монголо-Тибетской экспедиция 1923–1926 / ред.-сост. Т. И. Юсупова, сост. А. И. Андреев. Научное Наследство. Т. 30. СПб.: Наука, 2003. 1039 с. (*Petr Kuz'mich Kozlov. Dnevniki Mongolo-Tibetskoi ekspeditsiyi 1923–1926 /*

¹⁵ МУУТА. X. 23. Д. 1. Хн. 49. х. 49.

¹⁶ МУУТА. X. 23. Д. 1. Хн. 161. х. 50.

¹⁷ МУУТА. X. 23. Д. 1. Хн. 66. х. 60–61.

¹⁸ МУУТА. X. 23. Д. 1. Хн. 161. х. 52.

¹⁹ 1925 онд Б. Я. Владимирцовтой хамт явсан Б. Б. Барадины өдрийн тэмдэглэлийг Номинхановын өдрийн тэмдэглэл хэмээн андуурч 2016 онд «Bibliotheca orientalis» цувралын LXII-т хэвлүүлсэн байна.

- Redaktor-sostavitel' T. I. Yusupova, sostaviteli A. I. Andreev. Nauchnoe Nasledstvo. T. 30. SPb.: Nauka, 2003. 1039 s.).
- Котвич, 2011: Из эпистолярного наследия В. Л. Котвича / сост. Ч. Дашдаваа, С. Цолмон, Д. Наранжаргал, Ц. Цогзолмаа. Улан-Батор: Бемби сан, 2011. 414 с. (Iz epistol'yarnogo naslediya V. L. Kotvicha / sost. Ch. Dashdavaa, S. Tsolmon, D. Naranjargal, Ts. Tsogzolmaa. Ulan-Bator: Bembi san, 2011).
- Носов, 2019: *Носов Д. А.* Отчеты В. А. Казакевича (1896–1937) о поездках по Монголии в архивах Санкт-Петербурга // Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Программа тезисы. Улаанбаатар, 2019 (*Nosov D. A.* Otchet V. A. Kazakevicha (1896–1937) o poezdkah po Mongolii v arhivah Sankt-Peterburga // Kul'turnoe nasledie mongolov: Programma tezisy. Ulaanbaatar, 2019).
- Сэрээтэр, 2002: *Сэрээтэр Ч., Цэрэв Х., Чадраа Б.* Монгол улсын шинжлэх ухааны академийн түүх. Улаанбаатар: Бемби сан, 2002. 285 х. (*Serreter Ch., Chadraa B.* Mongol ulsyn schinzhlekh ukhaany akademiin tuukh. Ulaanbaatar: Bembi san, 2002. 285 kh.)
- Улымжиев, 1998: *Улымжиев Д. Б.* Оросын Монгол судлал. XIX зууны хоёрдугаар хагас XX зууны эхэн үе Монголч эрдэмтдийн Петербургийн дэг сургууль. Орос хэлнээс монгол хэл рүү орчуулсан Н. Пүрэвжав. Улаанбаатар: Эрдэм, 1998. 214 т. (*Ulymzhiev D. B.* Mongol sudlal XIX suuny khojordugaar khagas XX suuny ekhen ue Mongolch erdemtdiyin Peterburgiyin deg surguul, Oros khelnees mongol khel ruu orchuuksan N. Purevzhav. Ulaanbaatar: Erdem, 1998. 214 t.)
- Номинханов, 2016: *Номинхановын Ц-д.* 1924–1925 онд Баруун Монголд хийсэн судалгаа-II. Эрхлэн хэвлүүлсэн: На. Сүхбаатар, Гар бичмэлээс цахим бичвэрт бичиж, хөрвүүлэг, орчуулга хийсэн На. Сүхбаатар, Т. Ганцогт. Bibliotheca oiratica LXII. Улаанбаатар: Соёмбо, 2016. 210 х. (*Nominkhanovyn Ts-d.* 1924–1925 онд Баруун Монголд khiysen sudalgaa-II. Erkhlen khevluulsen: Na. Sukhbaatar, Gar bichmelees tsakhim bichvert bichizh, khovruuleg, orchuulga khiysen Na. Sukhbaatar, T. Hantsogt. Bibliotheca oiratica LXII. Ulaanbaatar: Soyombo, 2016. 210 kh.)
- Юсупова, 2018: *Юсупова Т. И.* Советско-монгольское научное сотрудничество. Становление, развитие и основные результаты. 1921–1961. СПб.: Нестор-История, 2018. 312 с. (*Yusupova T. I.* Sovetsko-mongol'skoe nauchnoe sotrudnichestvo. Stanovlenie, razvitie i osnovnye rezul'taty. 1921–1961. SPb.: Nestor-Istoriya, 2018. 312 s.)

Ch. Batdorzh Three Russian students who worked at the Mongolian Scientific Committee from 1923 to 1926

In the summer of 1923, three students from the Petrograd Institute of Living Oriental Languages (more widely known as Leningrad Institute of Orient) arrived in Mongolia. V. A. Kazakevitch, N. N. Babynin and A. V. Petrov, being guided by prominent Russian mongolists — V. L. Kotwicz and B. Ya. Vladimirtsov, were to do internship at the Mongolian Scientific Committee. Among these three V. A. Kazakevitch proved to be the most active and productive. During the entire period of his stay in the country, Kazakevitch took part in 5 expeditions and played an active role in the commission for drafting new terms.

N. N. Babynin also took part in the work of the commission and participated at the expedition to the Mergen-Gun Khoshuu of Sayn-noyon-khan aimak. Apparently, A. V. Petrov returned to Russia after a six-month study of the Mongolian language in the Setsen-Khan khuree of the Setsen-Khan aimak. The Mongolian Scientific Committee awarded V. A. Kazakevitch with a diploma for the successful fulfillment of numerous assignments. The successful training practice of these students in Mongolia opened a new page in Mongolian studies.

Key words: Petrograd Institute of Living Oriental Languages, Mongolian Scientific Committee, Expedition, Mongolian, Mongolian Studies, Setsen-khan Aimak, Sain-Noyon-khan Aimak, Mongolia, V. A. Kazakevich, N. N. Babynin, A. V. Petrov, J. Tseveen (Ts. Zh. Zhamtsarano).